



# ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

## Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих туршилтын төслийн тухай

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3.8 дахь хэсэг, 12 дугаар зүйлийн 12.1, 12.2, 12.8 дахь хэсэг, 23 дугаар зүйлийн 23.1.11, 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэг, 28 дугаар зүйлийн 28.8.2 дахь заалт, 29 дүгээр зүйлийн 29.11 дэх хэсгийг үндэслэн, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.2.28, 2.1.2.5, 2.1.2.8, 2.1.3.12 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор тус тус ТОГТООХ нь:

1.Төр, хувийн хэвшлийн түншлэлээр дамжуулан хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг хүртээмжтэй болгох зорилготой олон улсын жишигт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний "Job center" төвийг ажиллуулж, дэмжлэг үзүүлэх туршилтын төслийг нэгдүгээр, Зорилтот бүлгийн иргэний үүсгэн байгуулсан бичил, жижиг аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжих "Хөгжлийн гүүр төсөл"-ийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Туршилтын төслүүдийг Засгийн газрын хуралдаанаар танилцуулж, хэрэгжүүлэхийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад зөвлөсүгэй.

3.Төслийг хэрэгжүүлэх ажлыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн бодлогын газрын дарга Д.Ренчиндорж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Ц.Мөнхзул, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 онд батлагдсан төсвийн хүрээнд санхүүжилтийг хуваарилан, үйл ажиллагааны хэрэгжилтийн үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж тайлагнан, хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга З.Энхболд нарт тус тус даалгасугай.

ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.ЭНХ-АМГАЛАН

**ОЛОН УЛСЫН ЖИШИГТ НИЙЦСЭН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ “JOB CENTER” ТӨВИЙГ ДЭМЖИХ  
ТУРШИЛТЫН ТӨСӨЛ**

**НЭГ. ЗОРИЛГО**

Энэхүү туршилтын төслийн зорилго нь Олон Улсын жишигт нийцсэн хөдөлмөрийн бирж, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний үндэсний платформыг нэвтрүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлээр дамжуулан хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг нийгэмд хүртээмжтэй хүргэх зорилтын хүрээнд хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний “Job center” төвийн үйл ажиллагааг дэмжихэд оршино.

**ХОЁР. ЗОРИЛТ**

- 2.1. Туршилтын төслийн хүрээнд дараах зорилтыг дэвшүүлнэ:
  - 2.1.1. Олон Улсын жишигт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний “Job center” төвийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр дамжуулан 30-аас доошгүй байршилд нэвтрүүлэх;
  - 2.1.2. “Job center” төвд нийгмийн үйлчилгээг (орон сууцны хөнгөлөлтийн талаарх мэдээлэл, нийгмийн даатгал, нийгмийн халамж, сэтгэл зүйн үйлчилгээ гэх мэт) нэвтрүүлж, “Job center plus” үйлчилгээ үзүүлэх төв болгон өргөжүүлэх эхлэлийг тавих;
  - 2.1.3. Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд технологийн шийдлүүдийг нэвтрүүлэх;
  - 2.1.4. Туршилтын төсөлд хамрагдаж буй төвүүдийн үйл ажиллагааны менежментийг Олон Улсын жишигт нийцүүлнэ.

**ГУРАВ. ХАМРАХ ХҮРЭЭ**

- 3.1. Төсөлд дараах иргэн, байгууллага хамрагдана:
  - 3.1.1. Эрх бүхий байгууллагад бүртгүүлсэн хөдөлмөрийн бирж;
  - 3.1.2. Ажил олгогч байгууллага;
  - 3.1.3. Зорилтот бүлгийн иргэд (хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан, оюутан залуучууд, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай иргэн), ажилгүй иргэн, ажил хайгч иргэн, ерөнхий боловсролын ахлах ангийн суралцагчид болон бусад хэлбэрээр ажиллаж, орлогоо нэмэгдүүлэх сонирхолтой иргэд;
  - 3.1.4. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт, аймаг, дүүргийн хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, хэлтэс;
  - 3.1.5. Сургалтын үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага;

**ДӨРӨВ. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

- 4.1. “Job center” нь хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны А/19 дүгээр тушаалаар баталсан “Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний стандарт”-ын дагуу үзүүлнэ:
  - 4.1.1. Хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээ хийх;
  - 4.1.2. Хөдөлмөр эрхлэх хувийн төлөвлөгөө боловсруулах;
  - 4.1.3. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө өгөх;
  - 4.1.4. Ажилд зуучлах;

4.1.5. Ажил олгогчид зориулсан зөвлөгөө, мэдээлэл өгөх, сургалт зохион байгуулах;

4.1.6. Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах;

4.1.7. Өдөрлөг яармаг зохион байгуулах.

4.2. "Job center plus" үйлчилгээ үзүүлэх төв болгон өргөжүүлэх хүрээнд хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг нийгмийн үйлчилгээтэй хослуулан үзүүлнэ.

4.3. Хүн амын бүлэг болон эдийн засгийн салбараар төрөлжсөн төв байгуулна.

4.4. Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд технологийн (утас, цахим, мобайл аппликейшн гэх мэт) шийдлүүдийг нэвтрүүлж, "E-Job" платформд "Job center" тусгайлсан модуль үүсгэнэ.

4.5. Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн сургалтын байгууллагуудтай хамтран ажиллах замаар үйлчилгээнд хамрагдаж буй иргэдэд сургалт, ажил зуучлалын цогц үйлчилгээг үзүүлнэ.

4.6. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ үзүүлдэг байгууллагын ажилтныг чадавхжуулах сургалтаар бэлтгэж, ур чадварыг хөгжүүлнэ.

4.7. Улсын хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний "Job center" шинэ брэндийг үүсгэж, олон нийтэд сурталчлан таниулна.

4.8. Туршилтын төсөлд хамрагдаж буй төвүүдийн үйл ажиллагааны менежментийг олон улсын жишигт нийцүүлэх загварыг боловсруулна.

### **ТАВ. ТӨСЛИЙН ХУГАЦАА**

5.1. 2025 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хугацаанд хэрэгжүүлнэ.

5.2. Туршилтын төсөл амжилттай хэрэгжсэн тохиолдолд үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

### **ЗУРГАА. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

6.1. Төслийн өдөр тутмын үйл ажиллагаа, зохион байгуулалтыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар болон түүний эрх олгосон байгууллага хамтран ханган ажиллана.

6.2. Хөдөлмөрийн хувийн биржүүд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны А/54 дүгээр тушаалаар баталсан "Хөдөлмөрийн хувийн биржийг бүртгэж, санхүүжилт олгох журам"-ын дагуу хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг үзүүлнэ.

6.3. "Job center plus" үйлчилгээг үзүүлэхэд холбогдох төрийн болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллана.

6.4. Ахмад настан, оюутан залуучуудын бүлгээр, барилга, аялал жуулчлалын салбараар төрөлжсөн төвүүдийг байгуулж, холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллана.

6.5. "E-Job" платформд "Job center" тусгайлсан модуль үүсгэх, утас, цахим, мобайл аппликейшн гэх мэт сувгуудаар хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг үзүүлэхэд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.

6.6. Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамрагдаж буй иргэдийг хөдөлмөрт бэлтгэх, мэргэжлийн сургалтад хамруулж, суралцагчдыг ажилд зуучлах үйлчилгээг үзүүлнэ.

6.7. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ үзүүлдэг байгууллагын ажилтнуудыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтээс дүгнэлт гаргасан зөвлөх бэлтгэх хөтөлбөрийн дагуу бэлдэнэ.

6.8. Хэвлэл мэдээллийн боломжит бүх сувгууд, орчин үеийн дэвшилтэт технологийн хэлбэрүүдийг ашиглан "Job center" төвийн үйл ажиллагааг нийгэмд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулна.

6.9.Олон Улсын туршлагыг судлах замаар хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагуудад шинэ менежментийн удирдлага, зохион байгуулалтыг нэвтрүүлнэ.

6.10.Туршилтын төслийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар баталсан удирдамжийн дагуу хэрэгжүүлнэ.

### **ДОЛОО. САНХҮҮЖИЛТ**

7.1.“Job Center” төвүүдэд үйл ажиллагаа явуулж буй хувийн биржийн санхүүжилтийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны А/54 дүгээр тушаалаар баталсан “Хөдөлмөрийн хувийн биржийг бүртгэж, санхүүжилт олгох журам”-ын дагуу тооцон Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгоно.

7.2.“Job Center” төвийн түрээсийн зардлын дэмжлэгийг туршилтын хугацаанд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр дүнтэй уялдуулан санхүүжүүлнэ.

7.3. “Job Center” төслийн багт туршилтын хугацаанд санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.

### **НАЙМ. ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ**

8.1.Эрх бүхий байгууллага хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ үзүүлэх шаардлага хангасан хөдөлмөрийн хувийн биржүүдэд “Job center” төв брэндийг ашиглах эрхийг олгож, үйл ажиллагаанд нь хяналт тавина.

8.2.Туршилтын төслийн хэрэгжилтийн явцад Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар болон эрх бүхий байгууллага хяналт хийх ба уг хяналтын удирдамжийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын тушаалаар батална.

8.3.Эрх бүхий байгууллага хяналтын тайланг сар бүр Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хүргүүлнэ.

8.4.Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар хэрэгжилтийн тайланг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд дүгнэлтийн хамт улирал тутам мэдээлж тайлагнана.

8.5.Тухайн төслийн үе шат бүр дээр хэрэгжилтийн үр дүнгийн тайланг хэлэлцэж, дараагийн шатанд сайжруулах арга хэмжээг тусган, төслийн дараагийн төлөвлөлтөд сайжруулалтыг оруулах саналыг эрх бүхий байгууллагын удирдлагаар дамжуулан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт тус тус хүргүүлнэ.

## ЕС. ТӨСЛИЙН ҮР ДҮН

№	Хүлээгдэж буй үр дүн	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилт	Мэдээлэл цуглуулах арга
1	Үр дүн 1. Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний "Job center" төвийг аймаг, дүүргийн хэмжээнд байгуулсан байна.	Байгуулсан "Job center" төвийн тоо	4	30	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын хагас, бүтэн жилийн үйл ажиллагааны тайлан
2	Үр дүн 2. "Job center plus" үйлчилгээг нийт төвийн 50%-иас багагүй хувьд нэвтрүүлсэн байна.	"Job center plus" үйлчилгээг нэвтрүүлсэн "Job center" төвийн тоо	-	15	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын хагас, бүтэн жилийн үйл ажиллагааны тайлан
3	Үр дүн 3. Хүн амын бүлэг болон эдийн засгийн салбараар төрөлжсөн 6-аас доошгүй төв үйл ажиллагаагаа эхлүүлсэн байна.	Хүн амын бүлэг болон эдийн засгийн салбараар төрөлжсөн "Job center" төвийн тоо	-	6	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын хагас, бүтэн жилийн үйл ажиллагааны тайлан
4	Үр дүн 4. Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд технологийн (утас, цахим, мобайл аппликейшн гэх мэт) шийдлүүдийг нэвтрүүлж, "E-Job" платформд "Job center" тусгайлсан модуль үүсгэсэн байна.	Нэвтрүүлсэн цахим үйлчилгээний тоо	-	2	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын хагас, бүтэн жилийн үйл ажиллагааны тайлан
5	Үр дүн 5. "Job center" төвд ажиллаж буй ажилтан бүр сургалтад хамрагдаж, бэлтгэгдсэн байна.	Сургалтад хамрагдаж, бэлтгэгдсэн ажилтны тоо	40	300	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын хагас, бүтэн жилийн үйл ажиллагааны тайлан; Эрх бүхий байгууллагын сургалтын тайлан
6	Үр дүн 6. "Job center" төвийн үйл ажиллагааг танилцуулах, сурталчлах видео, контент нэвтрүүлэг хийсэн байна.	Видео, контент нэвтрүүлгийн тоо	1	14	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын хагас, бүтэн жилийн үйл ажиллагааны тайлан

7	<p>Үр дүн 7. Туршилтын төсөлд хамрагдаж буй төвүүдийн үйл ажиллагааны менежментэд олон улсын ISO9001 стандартыг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангуулж, жишиг төв болох эхлэлийг тавьсан байна.</p>	<p>Нэвтрүүлсэн олон улсын стандартын тоо</p>	-	1	<p>Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын хагас, бүтэн жилийн үйл ажиллагааны тайлан; Эрх бүхий байгууллагын үйл ажиллагааны тайлан</p>
8	<p>Үр дүн 8. Төслөөр дамжуулан байнгын ажилд зуучлагдсан иргэний тоо 6000-аас цөөнгүй байна.</p>	<p>Байнгын ажилд зуучлагдсан иргэний тоо</p>	70	6000	<p>Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын хагас, бүтэн жилийн үйл ажиллагааны тайлан; Эрх бүхий байгууллагын үйл ажиллагааны тайлан</p>



## “ХӨГЖЛИЙН ГҮҮР” ТӨСӨЛ

### НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого болон Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан хүн амын бүлгүүдийн хөдөлмөр эрхлэлт, бизнес аж ахуй эрхлэлтийг дэмжих, бичил, жижиг бизнесийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийн орчныг сайжруулах, хөнгөлөлттэй санхүүжилтийг нэмэгдүүлэх зорилтуудын хэрэгжилтийг хангаж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль болон Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль тогтоомжийн хүрээнд зорилтот бүлгийн иргэний үүсгэн байгуулсан бичил, жижиг аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжинэ.

### ХОЁР. ЗОРИЛГО, ЗОРИЛТ

- 2.1. Зорилтот бүлгийн иргэний үүсгэн байгуулсан бичил, жижиг аж ахуйн нэгж, байгууллагын бизнес, аж ахуйн үйл ажиллагааг өргөтгөх, бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, хүртээмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, ажлын байр шинээр бий болгох боломжийг бүрдүүлэхэд төслийн зорилго оршино.
- 2.2. Төслийн зорилгыг дараахь зорилтын хүрээнд хэрэгжүүлнэ.
- 2.2.1. зорилтот бүлгийн иргэний үүсгэн байгуулсан бичил, жижиг аж ахуйн нэгж, байгууллагын бизнес, аж ахуйн үйл ажиллагааг өргөтгөх, хөгжүүлэх, ажлын байр шинээр бий болгоход шаардлагатай хөнгөлөлттэй зээл буюу санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.
- 2.2.2. зорилтот бүлгийн иргэний үүсгэн байгуулсан бичил, жижиг аж ахуйн нэгж, байгууллагын санхүү, бизнесийн чадавхи, ур чадварыг хөгжүүлэх, бараа, бүтээгдэхүүний худалдаа, борлуулалтыг дэмжих замаар бизнес, аж ахуйн үйл ажиллагааны зах зээлийг тэлэх, хэрэгцээт ажиллах хүчнээр хангах зэрэг санхүүгийн бус дэмжлэгт хамруулна.

### ГУРАВ. ХАМРАХ ХҮРЭЭ

- 3.1. Төсөлд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн болон бусад хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлийн төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагаанд хамрагдан санхүүгийн болон санхүүгийн бус дэмжлэг авч бизнес, аж ахуйн үйл ажиллагаагаа өргөтгөх, хөгжүүлэх зорилготой, хэрэгцээ шаардлагатай байгаа дараах аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулна.
- 3.1.1. хөгжлийн бэрхшээлтэй хүний үүсгэн байгуулсан аж ахуйн нэгж, байгууллага (50-аас доошгүй хувьд нь хөгжлийн бэрхшээлтэй хүн ажилладаг байх) байна;
- 3.1.2. гадаадаас эх орондоо эргэн ирсэн иргэний үүсгэн байгуулсан аж ахуйн нэгж, байгууллага байна.

### ДӨРӨВ. ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРЧИМ

- 4.1. Төслийн санхүүгийн болон санхүүгийн бус дэмжлэг үзүүлэхтэй холбоотой үйл ажиллагаа нь адил тэгш, нээлттэй, ил тод, нийтэд ойлгомжтой байна;
- 4.2. Төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын хамтын ажиллагааны хүрээ, талуудын эрх, үүрэг тодорхой байна;
- 4.3. Төслийн хэрэгжилт, хяналт, үнэлгээний үйл ажиллагаанд үр дүнд суурилсан зарчмыг баримтлана;

4.4.Төслийг хэрэгжүүлэгч нь авилгаас урьдчилан сэргийлэх, авлигаас ангид ажиллана;

4.5.Төсөлд хамрагдах аж ахуйн нэгж, байгууллага нь санхүү, зээлийн эрсдэл даах чадвартай байхад тулгуурлана.

### **ТАВ. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

5.1.Хөнгөлөлттэй зээлийн өмнөх дэмжлэг үзүүлнэ.

5.1.1.Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг хөнгөлөлттэй зээлийн талаарх мэдээллээр хангах, сурталчилгаа хийх, зээл авах шалгуур нөхцөлийг хангахуйц төсөл бичихэд дэмжлэг үзүүлэх, зөвлөн туслах үйлчилгээг санал болгох, шаардлагатай тохиолдолд зээлийн өмнөх сургалтанд хамруулна.

5.2.Хөнгөлөлттэй зээлийн арга хэмжээг хэрэгжүүлнэ.

5.3.Хөнгөлөлттэй зээлийн дараах дэмжлэг үзүүлнэ.

5.3.1.зээлд хамрагдсаны дараа аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангахад зөвлөх, борлуулалт, түрээсийн дэмжлэгт хамруулах, үндэсний болон олон улсын үзэсгэлэн худалдаанд оролцоход дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамруулна.

### **ЗУРГАА. ТӨСЛИЙН ХУГАЦАА**

6.1. 2025 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хугацаанд хэрэгжүүлнэ.

6.2.Туршилтын төсөл амжилттай хэрэгжсэн тохиолдолд үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

### **ДОЛОО. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

7.1.Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн болон санхүүгийн бус дэмжлэгт амжилттай хамрагдан дараагийн шатны санхүүжилт шаардлагатай байгаа аж ахуйн нэгж, байгууллагыг сонгож, хөнгөлөлттэй зээлд хамруулахаар санал болгоно.

7.2.Хөнгөлөлттэй зээлийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан болон Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан хооронд байгуулсан дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас олгоно.

7.3. Хөнгөлөлттэй зээлийг олгох нөхцөлийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан хооронд байгуулсан дамжуулан зээлдүүлэх гэрээгээр зохицуулна.

7.4.Хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулалтын арга хэмжээг Засгийн газрын 2020 оны 113 дугаар<sup>1</sup> тогтоолоор баталсан журмын дагуу зохион байгуулна.

7.5.Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага нь хөнгөлөлттэй зээл авсан аж ахуйн нэгж, байгууллага бие биеэсээ суралцах, туршлагаа хуваалцах, түншлэлийн харилцаа холбоо тогтоох, нэмүү өртгийн сүлжээнд холбох, үйлдвэрлэлийн дэвшилтэт технологи, санаачилгын талаар мэдээлэл авах болон зээл авсан иргэдийн үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулахад чиглэсэн үзэсгэлэн, яармаг зэрэг үйл ажиллагааг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бусад хөтөлбөрүүдтэй уялдуулан зохион байгуулна.

7.6.Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага хөнгөлөлттэй зээл авсан аж ахуйн нэгж, байгууллагад шинээр бий болсон ажлын байранд бүртгэлтэй ажилгүй иргэдийг зуучлан ажиллуулахад дэмжин хамтран ажиллана.

<sup>1</sup>"Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"



## НАЙМ. САНХҮҮЖИЛТ

- 8.1.Төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ:
- 8.1.1.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан;
- 8.1.2.жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан.

## ЕС. ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

- 9.1.Төслийн хэрэгжилтийн явц болон хяналт-шинжилгээ, үнэлгээг Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан болон Жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний журамд нийцүүлэн хамтран зохион байгуулна.
- 9.2.Төслийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээнд захиргааны аргаар цуглуулсан тоон мэдээлэл, хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх чанарын мэдээлэл, мөшгөх судалгаа болон үр шим хүртэгчдийн сэтгэл ханамжийн судалгаа зэрэг арга хэрэгслийг зохистой ашиглана.
- 9.3.Хөнгөлөлттэй зээлд хамрагдсанаас хойш 6 сарын дараа үр шим хүртэгчдийн сэтгэл ханамжийг үнэлэх зорилгоор мөшгөх судалгаа хийнэ.
- 9.4.Хөнгөлөлттэй зээлийн олголт болон төлөлтийн мэдээг Жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад Дамжуулан зээлдүүлэх гэрээний хавсралтаар батлагдсан маягтын дагуу сар бүр тогтмол мэдээлж, тайлагнана.
- 9.5.Төслийн үйл ажиллагааны мэдээ, үр дүнгийн тайланг улирал тутам холбогдох төрийн захиргааны байгууллагууд Хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн болон Жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тус тус тогтмол мэдээлж, тайлагнана.

## АРАВ. ТӨСЛИЙН ҮР ДҮН

- 10.1.Төсөлд хамрагдсан зорилтот бүлгийн иргэний үүсгэн байгуулсан бичил, жижиг аж ахуйн нэгж, байгууллага нь хөнгөлөлттэй зээлийн дэмжлэгт хамрагдаж бизнесийн хөгжлийн дараачийн үе шатанд хүрч хөгжсөн байна.
- 10.2.Төсөлд хамрагдсан зорилтот бүлгийн иргэний үүсгэн байгуулсан бичил, жижиг аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн мэдлэг, боловсрол нэмэгдэж, бизнес, аж ахуйн үйл ажиллагаа тогтвортой эрхлэх чадавх сайжирсан байна.
- 10.3.Төсөлд хамрагдсан зорилтот бүлгийн иргэний үүсгэн байгуулсан бичил, жижиг аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэл, үйлчилгээний борлуулалт, худалдаа, хамтын ажиллагааны цар хүрээ өргөжин тэлсэн байна.
- 10.4.Төсөлд хамрагдсан зорилтот бүлгийн иргэний үүсгэн байгуулсан бичил, жижиг аж ахуйн нэгж, байгууллагын ажлын байр нэмэгдэж, ажиллах хүчний хэрэгцээ хангагдсан байна.
- 10.5.Төсөлд хамрагдсан зорилтот бүлгийн иргэний үүсгэн байгуулсан бичил, жижиг аж ахуйн нэгж, байгууллагад шинээр бий болсон ажлын байрны 50.0 хувиас багагүй хэсэгт ажилгүй иргэдийг зуучлан оруулсан байна.
- 10.6.Төсөлд хамрагдан амжилттай хэрэгжүүлсэн /зээлийг эргэн төлөлтийн хугацаанд төлсөн зэрэг байх/ зорилтот бүлгийн иргэний үүсгэн байгуулсан бичил, жижиг аж ахуйн нэгж, байгууллагыг бизнесийн хөгжлийн дараачийн үе шатны холбогдох дэмжлэгийн үйл ажиллагаанд холбон зуучилсан байна.